



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 1 дүгээр сарын 22 өдөр Дугаар 07

Хэрлэн сум

VII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 7 дугаар хуралдаан 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн 16:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 97,6 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Улаанбаатар хотоос иргэдийг татан авах талаар хэлэлцэх,
Эрүүл мэндийн газар, Авто тээврийн төв

2. Улаанбаатар хотоос Дорнод аймгийн төв, бусад сумдруу иргэдийг татан авах, тусгаарлалт, ажиглалтын үйл ажиллагааг зохион байгуулах түр журмын төсөл танилцуулах,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс

3. Аймгийн Онцгой комиссын 2020 оны “Эмнэлгийн болон хувийн бариа заслын үйлчилгээг зохицуулах тухай” 09 дүгээр, “Шуудан тээврийн үйлчилгээнд хязгаарлалт тогтоох тухай” 10 дугаар тогтоолуудын хүчинтэй хугацаа дууссан тул цаашид үргэлжлүүлэн сунгах эсэх талаар хэлэлцэх,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс


ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

1.1. Улаанбаатар хотоос Дорнод аймгийн иргэдийг татан авах, тусгаарлалт, ажиглалтын үйл ажиллагааг зохион байгуулах түр журмыг шинэчлэн батлуулахыг,

Хоёр. Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Мөнхтөр,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ч.Оюунаа нарт:

2.1. Хан-Уул дүүргийн “Мишээл Экспо” төвийн баруун талд “Лавай” төвийн гаднаас 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 17:00 цагт Улаанбаатар хотоос иргэдийг татан авах 4 автобусыг Дорнод аймаг руу хөдөлгөөн үйлдүүлэхийг,

/  / М.Бадамсүрэн

/  / Э.Ганжигүүр

2.2.Дорнод аймгаас Улаанбаатар хот руу зорчих хот хоорондын тээврийн автобусанд буцаж ирэхгүй гэсэн шаардлагыг зөвшөөрсөн иргэдийг тээвэрлэхийг,

Гурав.АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

3.1.Аймгийн Онцгой комиссын 2020 оны “Эмнэлгийн болон хувийн бариа заслын үйлчилгээг зохицуулах тухай” 09 дүгээр тогтоолд заасан хугацааг үргэлжлүүлэн 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгахыг,

3.2.Аймгийн Онцгой комиссын 2020 оны “Шуудан тээврийн үйлчилгээнд хязгаарлалт тогтоох тухай” 10 дугаар тогтоолын хугацааг үргэлжлүүлэн тодорхойгүй хугацаагаар хориглохыг,

Дөрөв.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.1.Сармисны ханд 70 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас зарлагдаж аймгийн Цагдаагийн газарт шилжүүлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА



М.БАДАМСҮРЭН

БҮСИЙН ТӨВ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН
ГАЗРЫН АХМАД

Э.ГАНЖИГҮҮР